

МОНГОЛ УЛСЫН НОГООН ТАКСОНОМИ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сард батлав

ТАНИЛЦУУЛГА 4	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ 12	БОХИРДОЛ БАГАТАЙ ЭРЧИМ ХҮЧ 14
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ 15	НОГООН БАРИЛГА 17	БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 19
ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ 20	ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ 22	КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР 24

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА, САНГИЙН САЙД, ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН
КОРПОРАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ТУШААЛ


2019 оны 12 сарын 17-ны өдөр

Дугаар А-302/601/267/62 Улаанбаатар хот

“Ногоон таксономи”-ийг батлах тухай

Олон улсад мөрдөгдөж буй Ногоон эдийн засгийн нийтлэг зарчим, шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлж, Монгол улсын Ногоон эдийн засгийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27² зүйлийн 5 дахь хэсгийн 5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

“Ногоон таксономи”-ийг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	САНГИЙН САЙД	ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИАГ
			
Б.ХАГВАСҮРЭН	Д.БАЯРСАЙХАН	Ч.ХҮРЭЛБААТАР	Х.БУМ-ЭРДЭНЭ

УЛААНБААТАР ХОТ ТТЗ7953-6 8108994

Талархал

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, олон талт оролцогчдын итгэл, хичээл зүтгэлээр Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн хөтөлбөр (ТоС Хөтөлбөр) амжилттай хэрэгжиж байгаа билээ. Ногоон таксономи хэмээх энэхүү баримт бичгийг боловсруулан танилцуулж байгаа явдал нь Монгол Улсын Үндэсний тогтвортой санхүүгийн замын зурагт заасны дагуу банк санхүү болон санхүүгийн бус салбаруудад тогтвортой санхүү, ногоон эдийн засгийг цогцлоох томоохон алхам болж байна.

Энэхүү баримт бичгийг Монголын Тогтвортой санхүүгийн хөгжлийн холбоо (ТоС Холбоо), БНХАУ-ын Цинхуа их сургуулийн Санхүү, хөгжлийн төв болон Олон улсын санхүүгийн корпораци (IFC) зэрэг байгууллагуудын дэмжлэг, оролцоотойгоор боловсруулсан. Тус баримт бичгийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци зэрэг байгууллагын бодлогын дэмжлэгтэйгээр буюу Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталлаа. Энэ үр дүнд хүрэхэд Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам онцгой үүрэгтэй оролцсоныг дурдах нь зүйтэй. Түүнчлэн өөрийн үнэт цагийг зориулсан мэргэжилтнүүд, тэр дундаа Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Зам тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандартчлал хэмжилзүйн газар, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Үндэсний хөгжлийн газар, Уур амьсгалын асуудал хариуцсан тусгай элч, Нидерландын хөгжлийн банкны хамт олонд гүн талархал илэрхийлье.

Үүний зэрэгцээ Ногоон таксономи баримт бичгийн хэрэглээ, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхэд арилжааны банкуудаас үнэтэй санал, зөвлөмж өгч ажилласныг дурдах нь зүйтэй юм. Бидний зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцож санал өгсөн бизнесийн болон төрийн бус байгууллагууд, их сургуулиуд, төслийн нэгжүүд, олон улсын байгууллагуудад талархал илэрхийлж буйг хүлээн авна уу.

Товчилсон нэрсийн жагсаалт

ToC	Тогтвортой санхүү
BREEAM	Building Research Establishment Environmental Assessment Method (Барилгын судалгааны газрын байгаль орчны үнэлгээний аргачлал)
BRT	Bus rapid transit (Хурдны автобус)
CSP	Concentrated Solar Plant (Нарны төвлөрсөн эрчим хүчний станц)
EDGE	Excellence in Designs for Greater Efficiencies (Ногоон барилгын стандарт: Үр ашгийг дээшлүүлэх дэвшилтэт загвар)
GOTS	Global Organic Textile Standard (Дэлхийн органик нэхмэлийн стандарт)
LEED	Leadership in Energy and Environmental Design (Ногоон барилгын стандарт: Эрчим хүч, байгаль орчны загвар дахь манлайлагч)
PM2.5	Particulate Matter 2.5 (2.5 микрометртэй дүйцэх диаметр бүхий агаар бохирдуулагч тоос)
PV	PhotoVoltaic (Фотоволтаик буюу гэрлийн энергийг цахилгаан энерги болгох технологи)
REACH	Registration, Evaluation, Authorisation and Restriction of Chemicals (Химийн бодисын бүртгэлжүүлэлт, үнэлгээ, зөвшөөрөл ба хязгаарлалт)

Нэг. НОГООН ТАКСОНОМИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Тодорхойлолт

Ногоон таксономи гэдэг нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглана. Ногоон таксономи нь аль нэг салбараар хязгаарлагдахгүй, бизнесийн бүхий л салбарыг хамаарах шалгуур үзүүлэлт юм.

1.2. Зорилго болон хамрах хүрээ

Ногоон таксономийг тодорхойлж, ашиглах нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг нөлөөг бууруулах, бохирдлоос хамгаалах, байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалтыг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зэрэгт чиглэсэн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ногоон санхүүжилтийн үйл ажиллагааны тодорхойлолт, жагсаалтыг гаргаж, суурь шаардлага тавих зорилготой.

Ногоон таксономи нь дараах зорилтуудтай. Үүнд:

1. Бодлого боловсруулагч нарт болон санхүүгийн байгууллагууд, бизнес эрхлэгч, бусад гол оролцогчдод ногоон санхүүжилтийн төслүүд, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлох болон хөгжүүлэхтэй холбоотой нийтлэг ойлголт, аргачлалыг өгөх;
2. Ногоон санхүүжилтийн төслүүдийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх хүсэлтэй хөрөнгө оруулагчдад итгэл, үнэмшил баталгаа өгөх, “ногоон”, “байгаль орчинд ээлтэй” хэмээх тодотголтой хуурамч төслүүд бий болох эрсдэлийг бууруулах;
3. Хувийн хэвшил, олон улсын санхүүгийн байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулагчид болон бусад эх үүсвэрүүдийг ашиглан ногоон санхүүжилтийн дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх;
4. Ногоон төслүүдийг санхүүжүүлж буй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүртгэх, Монгол Улсын ногоон хөгжил болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого, зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх;
5. Ногоон санхүүжилттэй холбоотой бизнесийн боломжууд, зах зээлийн

хөгжлийг хурдасгахад чиглэсэн ногоон санхүүжилтийн үндэсний бодлого, зохицуулалтыг сайжруулах

Ногоон таксономи буюу ногоон төслийн тодорхойлолт, ангиллыг хэрэглээний зээл, байгууллагын санхүүжилт, төслийн санхүүжилт, жижиг дунд бизнесийн санхүүжилт, ногоон бонд, хувьцаа, даатгал, зээлийн баталгаа, тусламж, санхүүгийн зөвлөгөө өгөх болон техникийн туслах үйлчилгээ зэрэг олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэгслүүдэд суурь үзүүлэлт, тавих шаардлага болгон ашиглах боломжтой.

Ногоон таксономийг дээрх байдлаар өргөн хүрээнд ашиглах боломжтойгоос гадна зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй оролцогчид мөн хэрэглэдэг. Доорх хүснэгтэд ногоон таксономийг ашиглах гол оролцогчид болон ашиглах зориулалтуудын жишээг харуулав:

Зах зээл дээрх гол оролцогчид	Ашиглах зориулалтууд (энд дурдсанаар хязгаарлагдахгүй)
Санхүүгийн байгууллагууд (банк, банк бус санхүүгийн байгууллагууд, хөгжлийн банкууд, орон сууцны зээлийн корпорациуд, байгууллагын хөрөнгө оруулагчид, зээлийн батлан даалтын сангууд, даатгалын компаниуд гэх мэт)	- Ногоон санхүүжилтийн стратеги, бодлого боловсруулах, - Ногоон санхүүжилт хийх эсвэл татах боломжит төслүүд, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлж, судлах, хөрвүүлэх, - Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний шалгуурыг боловсруулах, - Зээлийн багц дахь ногоон санхүүжилтийн урсгалыг хэмжих, тайлагнах, - Харилцагч, гол оролцогч талуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сургах зэрэгт ашиглах,
Бонд гаргагч байгууллагууд (компани, байгууллага, орон нутгийн удирдлага, засгийн газар)	- Ногоон бондоор санхүүжүүлэх төсөл, бизнесийн үйл ажиллагааны холбогдох шалгуурыг боловсруулах, - Бонд гарган бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдийг тодорхойлох, үнэлэх, - Бондын үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтыг хянах, - Хөрөнгийн хуваарилалтыг тайлагнах зэрэгт ашиглах,
Салбарууд (компани, байгууллага, корпорейт, жижиг дунд бизнесүүд, гарааны бизнес эрхлэгчид, мөн бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нар)	- Байгууллага, компанийн үйл ажиллагааны стратегид “ногоон” элементийг оруулах, - Ногоон технологитой холбоотой сонголтуудыг үнэлэх, харьцуулах, шийдвэр гаргах, - Ногоон төслүүд, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, - Ногоон санхүүжилтийн төслүүдийн техникийн болон үр дүнгийн шаардлагуудыг илүү ойлгох, тодорхойлох зэрэгтэй холбоотой үйл ажиллагаанд зааварчилгаа байдлаар ашиглах, - Харилцагч, гол оролцогч талуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сургах зэрэгт ашиглах,

Зах зээл дээрх гол оролцогчид	Ашиглах зориулалтууд (энд дурдсанаар хязгаарлагдахгүй)
Баталгаажуулалтын байгууллагууд (баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт хийдэг болон стандарт тогтоох чиг үүрэг бүхий байгууллагууд)	- Ногоон бонд гаргахын өмнөх болон гаргасны дараах үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох, - Ногоон төслүүдийг гэрчилгээжүүлэх, - Ногоон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг тодорхойлж патент олгох, - Хөрөнгийн ашиглалтыг хянах зэрэг үйл ажиллагаанд мөн ашиглах,
Бодлого боловсруулагчид	Ногоон таксономийг холбогдох стандартууд, гэрчилгээ, урамшууллын механизмууд, мөн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн өөрчлөлт зэргийг агуулсан ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын чиглэлийг тодорхойлж, хөгжүүлэхэд ашиглана.

1.3 Үндэслэл

Монгол Улс нь эдийн засгийн өсөлт, байгаль орчны болон нийгмийн сайн сайхны асуудлууд харилцан шүтэлцээтэй, тэнцвэртэй байдлаар оршин тогтнож, хөгжих асуудлыг чухалчлан үндэсний хөгжлийн бодлого стратегидаа тодорхойлсон байдаг. Үндэсний ногоон хөгжлийн бодлого (2014) болон Парисын хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаар Монгол Улс хүлэмжийн хийн одоо ялгаруулж буй түвшнийг 2030 он гэхэд 22.7 хувиар бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс гадна агаарын бохирдол нь эн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудал болоод байна. Энэ хүрээнд Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр (2017)-ийг баталж, агаарын бохирдлыг одоо байгаа хэмжээнээс даруй 80 хувиар бууруулах зорилгоор холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Түүнчлэн, Монгол Улс нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, усны хэрэглээг хэмнэх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, ажлын байр нэмэгдүүлэх, орлогын тэгш бус байдлыг бууруулах, тогтвортой, мэргэжлийн засаглалын тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой бусад зорилтуудыг тавин ажиллаж байна. Гэтэл зөвхөн Ногоон хөгжлийн бодлого (2014)-д тусгасан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхийн тулд 6.96 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байна¹.

Үндэсний зорилтот хувь нэмэр болон Засгийн газрын хүлээсэн бусад үүрэг амлалт, зорилтуудыг оролцуулан Нэгдсэн Үндэстний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн тооцоолсноор Монгол Улсын ногоон хөрөнгө оруулалтын жилийн хэрэгцээ 690 сая ам.доллараас 1.03 тэрбум ам.долларын хооронд хэмжигдэж байна. Энэхүү тооцооллоос харахад зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт хангалтгүй бөгөөд хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын оролцоо, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

1 <http://ndc.mne.gov.mn/mn>

Монгол Улсын банкны салбар энэхүү чиг хандлагыг дэмжин тогтвортой санхүүгийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсээр ирсэн. Банкууд 2013 оноос хойш сайн дурын үндсэн дээр, зах зээлийн шаардлагад суурилсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн асуудлыг зээл, санхүүжилт олгох, хөрөнгө оруулалт хийх шийдвэртээ анхаардаг болгох зорилгоор Монголын Тогтвортой санхүүжилтийн (ТоС)-ийн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байна.

2018 онд Монгол Улс нь “Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг-2030” баримт бичгийг бүх оролцогч талуудын оролцоотойгоор боловсруулсан бөгөөд уг баримт бичигт зөвхөн банкны салбарт бус даатгал, хөрөнгийн зах, хөрөнгө оруулагчид зэрэг гол тоглогчдыг оролцуулан санхүүгийн салбарт тогтвортой санхүүгийн үзэл баримтлалтай холбоотой зарчмуудыг хөгжүүлэх арга зам, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан юм. Эдгээр бодлогын арга хэмжээнүүдийг цаашид амжилттай хэрэгжүүлэхэд саад болж буй гол хүчин зүйлүүдийн нэг нь хөрөнгө оруулалт, санхүүжилт (ногоон зээл олгох, ногоон бонд гаргах)-тэй холбоотой байгаль орчинд ээлтэй төслийн талаарх олон нийтийн ойлголт дутмаг, тогтсон тодорхойлолт, мэдээлэл байхгүй байгаа явдал байна. Ногоон ангилал, шалгууртай болсноор банк санхүү, бизнесийн байгууллагууд ногоон хөрөнгө оруулалт, санхүүжилт татах, ногоон бүтээгдэхүүнүүд шинээр гаргах, цаашлаад тэдгээрийг бүртгэлжүүлэн хянаж, ногоон статистик гаргах боломжийг бүрдүүлэх суурь бүрдэж, улмаар Монгол Улсын ногоон хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулна.

Улсын Их Хурал (УИХ)-аас баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн баримт бичгийн 3 дугаар хэсэг болох Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх ажлын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний гуравт “Олон улсад мөрдөгдөж байгаа тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг нэвтрүүлэх” бодлого, зорилтын хүрээнд “тогтвортой санхүүжилт, ногоон санхүүжилт, ногоон зээлд тавих тусгайлсан шалгуурыг олон улсын шилдэг туршлагад үндэслэн тогтоох” арга хэмжээг тодорхойлсон. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ногоон таксономийг боловсруулан ашиглах нь тогтвортой санхүүгийн тогтолцоог бодитой хөгжүүлэх, цаашлаад байгаль орчны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, хорт хий, хог хаягдлын ялгаруулалтыг бууруулахад чиглэсэн салбаруудад хөрөнгө оруулалтыг чиглүүлэхэд чухал нөлөө үзүүлэх болно.

1.4 Зарчмууд

Ногоон таксономийг дараах 6 үндсэн зарчмын дагуу боловсруулсан²:

Зарчим 1: Үндэсний бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах

Ногоон төсөл, бизнесийн үйл ажиллагааны тодорхойлолт, таксономи нь уур амьсгалын өөрчлөлт болон ногоон хөгжлийн чиг хандлагатай уялдан Монгол Улсын холбогдох бодлого, стратеги, хөтөлбөрүүдэд заасан гол зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой.

2 БНХАУ-ын Ногоон бондын катологи, Хятад улсын Нийгэм болон банкны ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх хороо, 2015 он

Зарчим 2: Байгаль орчинд тулгарч буй бэрхшээл, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх

Ногоон төсөл, бизнесийн үйл ажиллагааны тодорхойлолт, таксономи нь Монгол Улсын хувьд тулгараад буй байгаль орчинтой холбоотой: 1) уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон сөрөг нөлөөллийг бууруулах; 2) агаар болон орчны бохирдлыг бууруулах; 3) байгалийн нөөцийн хамгаалалт 4) иргэдийн амьжиргааг сайжруулах зэрэг бэрхшээл, асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэхэд чиглэсэн байна.

Зарчим 3: Байгаль орчинд хог хаягдал, бохирдол ихээр ялгаруулдаг эдийн засгийн гол салбаруудын үйл ажиллагааг хамарсан байх

Ногоон төсөл, бизнесийн үйл ажиллагааны тодорхойлолт, таксономи нь байгаль орчинд хог хаягдал, бохирдол ихээр гаргадаг эдийн засгийн гол салбаруудын үйл ажиллагааг хамарч эдгээр салбаруудын үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд ээлтэй тогтвортой үйл ажиллагаанд шилжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Зарчим 4: Олон улсын холбогдох стандартууд болон сайн туршлагуудтай нийцсэн байх

Монгол Улсын хувьд одоогоор холбогдох стандартууд байхгүй байгаа тул ногоон төсөл, бизнесийн үйл ажиллагааны тодорхойлолт, таксономи нь олон улсын холбогдох стандартууд болон сайн туршлагуудтай нийцсэн байх хэрэгтэй.

Зарчим 5: Байгаль орчин, нийгэм болон сайн засаглалын холбогдох стандартуудыг хангасан байх

Ногоон таксономид тусгасан төсөл, бизнесийн үйл ажиллагаанууд нь байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын холбогдох зохицуулалт болон стандартууд (тухайлбал, Монголын тогтвортой санхүүгийн зарчмууд болон 4 салбарын байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын гарын авлагууд³)-ыг хангасан байх хэрэгтэй.

Зарчим 6: Байнга хянан сайжруулж байх

Ногоон төсөл, бизнесийн үйл ажиллагааны тодорхойлолт, таксономийг бодлогын шилжилт, өөрчлөлт, шинжлэх ухааны хөгжил дэвшил, технологийн өөрчлөлт, бизнесийн хэрэгцээ шаардлага зэрэгтэй уялдуулан тогтмол хянаж, тухай бүр боловсруулалт, сайжруулалтыг хийж байх хэрэгтэй.

3 Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүнд өндөр хувь нэмэр бүхий, хүлэмжийн хийн ялгарал ихтэй 4 салбарт боловсруулсан: Барилга, Боловсруулах, Уул уурхай, Хөдөө аж ахуйн салбар.

1.5 Бодлогын уялдаа

Ногоон таксономийг Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт болон ногоон хөгжлийн асуудалтай холбоотой дараах бодлого, стратеги, хөтөлбөрүүдэд тулгуурлан боловсруулсан болно. Үүнд:

- Монгол Улсын Алсын хараа 2050: Урт хугацааны хөгжлийн баримт бичиг, 2020
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд (2016-2030 он), 2016
- Монгол Улсын Үндэсний зорилтот хувь нэмэр (2030 он), 2015
- УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Ногоон хөгжлийн бодлого
- УИХ-ын 2015 оны 63 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого
- УИХ-ын 2011 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр
- Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр
- УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөр
- УИХ-ын 2005 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”
- УИХ-ын 2015 оны 49 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2015 он)
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль (2015 он)
- Үндэсний REDD+ Бэлэн байдалд бэлтгэх Замын зураг
- Монгол Улсын үндэсний тогтвортой санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замын зураг (2018 он)

Ногоон таксономийн ангилал бүртэй холбогдох гол бодлогын зорилтуудыг дараах хүснэгтэд тусгав.

Но	Ангилал	Холбогдох гол бодлогын зорилтууд
1	Сэргээгдэх эрчим хүч	- Эрчим хүчний салбар дахь хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2030 он гэхэд 20 хувиар бууруулах; - Нийт эрчим хүч үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 2014 онд 7.62 хувь байсныг 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд тус тус хүргэх; - Дулааны цахилгаан станцын үйлдвэрийн дотоодын цахилгааны хэрэглээг (үйлдвэрийн цахилгаан хэмнэлт) 2014 онд 14.4 хувь байсныг 2020 онд 11.2 хувь, 2030 он гэхэд 9.14 хувьд тус тус хүргэх; - Цахилгаан дамжуулах шугам сүлжээний цахилгаан алдагдлыг 2014 онд 13.7 хувь байсныг 2020 онд 10.8 хувь, 2030 он гэхэд 7.8 хувьд тус тус хүргэх; - Зорилтот аж ахуйн нэгжүүдийн эрчим хүчний хэмнэлтийг 15 хувиар сайжруулах (1-р үе шат).
2	Бохирдол багатай эрчим хүч	
3	Эрчим хүчний хэмнэлт	
4	Ногоон барилга	- Барилгын дулаан алдагдлыг 2014 оны түвшинтэй харьцуулахад 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 40 хувьд хүртэл тус тус бууруулах; - Улаанбаатар хотын орон сууцны угсармал 18,184 айл өрхийн байрны дулаалгыг сайжруулах; - Хотын нийт барилга байгууламжид ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн эзлэх хувийг 25 хувьд хүргэх.
5	Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа	- Бохирдол: Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийг 80 хувиар бууруулах, боловсруулаагүй түүхий нүүрсний хэрэглээг цахилгаан станцад хэрэглэхээс бусад зориулалтаар ашиглахыг хориглох, агаарын болон байгаль орчны бохирдлыг 2025 он гэхэд доод тал нь 50 хувиар бууруулах; - Хог хаягдал: Газарт булагдаж буй хатуу хог хаягдлын хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 40 хувьд хүртэл бууруулж, хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааны менежментийг сайжруулан, дахин боловсруулах үйл ажиллагааг нэмэгдүүлэх, мөн нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих. Нийт хог хаягдал дотор дахин боловсруулсан хаягдлын хэмжээг 30 хувь хүртэл өсгөх.
6	Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ	- Хүн амын 90-ээс доошгүй хувьд нь ундны цэвэр ус хэрэглэх боломжийг бий болгох; - Гадаргын усны нөөц болон гол мөрний ай сав газруудын байгалийн унаган эко системийг хамгаалах замаар усны нөөцийг хадгалах; - Усны нөөц, гол мөрөн болон усны эх үүсвэрүүдийн 50-иас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Улаанбаатар хот болон аж үйлдвэрүүд, мөн говийн бүсэд усны тогтвортой нийлүүлэлтийг бий болгох шийдлийг боловсруулах.

No	Ангилал	Холбогдох гол бодлогын зорилтууд
7	Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал	- Бэлчээр: Бэлчээрийн даац, хүчин чадалд тохирсон хэмжээнд мал сүргийн тоо толгойг хадгалан, бэлчээрийн тогтвортой менежментийн арга туршлагыг нэвтрүүлэх - Малчид, малчдын бүлэг, мөн жижиг дунд фермерүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих - Хөдөө аж ахуй: Тогтвортой хөдөө аж ахуй, ногоон технологид суурилсан экспортыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх, улмаар арьс шир, ноос ноолуур зэрэг түүхий эд материалын ногоон технологид суурилсан боловсруулалтыг 2020 онд 60 хувь, 2030 он гэхэд 80 хувь хүртэл тус тус нэмэгдүүлэх - Газар тариалангаас үүдэлтэй хөрсний доройтлыг бууруулах, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс арчлах агро техник болон усжуулах дэвшилтэт технологийг ашиглан, ойн бүсийг бий болгох замаар дотоодын буудай, төмс, хүнсний ногооны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх - Ой: Ойг устгах үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралтыг 2020 онд 2 хувь, 2030 он гэхэд 5 хувь хүртэл тус тус бууруулах - Бэлчээрийн менежмент: Хөрсний доройтолд орсон газар нутгийн 70 хувийг сэргээхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, нийт газар нутгийн 30 хувийг 2030 он гэхэд төрийн хамгаалалтад авах - Эко-аялал жуулчлал: Эко-аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон хөгжүүлэх, Монголын нүүдэлчин соёл зан заншлыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэх, жилдээ гадаадын 2.0 сая жуулчин хүлээн авдаг болох
8	Карбон бага тээвэр	- Хосолсон хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 2014 онд 6.5 хувь байсныг 2030 он гэхэд 13 хувьд хүргэж нэмэгдүүлэх - Холбогдох татвар, байгаль орчны төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд зорчих тээврийн хэрэгслийн түлшийг шингэн түлшнээс байгалийн хий рүү шилжүүлэх - Байгаль орчинд ээлтэй олон нийтийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх (жишээ нь BRT) - Байгаль орчин, хүний эрүүл мэнд, биологийн төрөл зүйлд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй тээврийн сүлжээ болон дэд бүтцийг хөгжүүлэх

Хоёр. НОГООН ТАКСОНОМИ

Монгол Улсын ногоон таксономийг дараах 8 ерөнхий чиглэлээр тодорхойлж байна. Үүнд:


1 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ			
Дэд ангилал	Технологи	Жишээ	Шалгуур
 1.1 Салхи	1.1.1 Эрчим хүчний үүсгүүр	Салхины цахилгаан станц, салхиар эрчим хүч гаргах төхөөрөмжүүд, салхин насос, салхин турбин, дээвэр дээр байрлах салхин турбинууд	
 1.2 Нар	1.2.1 Цахилгаан үүсгүүр (PV ⁴ & CSP ⁵)	Нарны PV станцууд, CSP станцууд, PV цахилгаан эрчим хүч дамжуулан станцууд	
	1.2.2 Жижиг хэмжээний нарны цахилгаан үүсгүүр	Гэр ахуйн хэрэгцээнд нийцсэн жижиг хэмжээний нарны цахилгаан үүсгүүр, жижиг суурин газрын цахилгааны хэрэглээг хангах төхөөрөмжүүд	
	1.2.3 Нарны коллектор	Нарны дулаан ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, нарны дулаанаар ус халаах систем, мөн эдийн засгийн бусад салбаруудад ашиглаж болох нарны цахилгаан үүсгүүр төхөөрөмжүүд	
1.3 Газрын гүний дулаан	1.3.1 Дулаан болон цахилгаан эрчим хүч үүсгэх төхөөрөмжүүд	Дүүргийн халаалтанд зориулсан газрын гүний дулаан ашиглан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх станцууд, газрын гүний дулааныг гаргах насос	
 1.4 Усан	1.4.1 Бага ба дунд чадлын усан цахилгаан станцууд (20MW-аас бага хэмжээний)	Гол мөрний урсац мөн ус хадгалах боломжтой болон боломжгүй байдлаар усны урсгалыг ашиглан цахилгаан эрчим хүч гаргах станцууд	
1.5 Бусад	1.5.1 Бусад дулаан үүсгэх төхөөрөмжүүд	Гол нуур цөөрмийн дулаан, агаарын дулаан ашиглах насос, бусад тоног төхөөрөмжүүд	

4 Фотоволтаик

5 Нарны төвлөрсөн эрчим хүчний станц

 1.6 Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх тоног төхөөрөмж, сүлжээний туслах дэд бүтэц	1.6.1 Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн гол машин тоног төхөөрөмж, бүрэлдэхүүн хэсгүүдийн үйлдвэрлэл. PV хавтан, CSP, насос, зэрэг нар, газрын гүний дулаан, салхи, усан цахилгаан үйлдвэрлэлийн бусад бүрэлдэхүүн хэсэг, тоног төхөөрөмжүүд	
	1.6.2 Сэргээгдэх эрчим хүч дамжуулах сайжруулсан шугамууд болон туслах дэд бүтэц	Сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг сайжруулахад чиглэсэн шинэ, өргөтгөсөн мөн сайжруулсан дамжуулах системүүд (шугамууд болон дэд станцууд), хадгалах системүүд (зай хураагуур, механик болон насос хадгалах систем), шинэ мэдээллийн технологи (ухаалаг сүлжээ болон жижиг сүлжээ)	
	1.6.3 Сэргээгдэх эрчим хүчний хураагуурын систем	Зай хураагуур, конденсатор зэрэг хураагуур төхөөрөмж, үйлдвэрлэл	

2 БОХИРДОЛ БАГАТАЙ ЭРЧИМ ХҮЧ			
Дэд ангилал	Технологи	Жишээ	Шалгуур
 2.1 Био эрчим хүч	2.1.1 Биотүлш үйлдвэрлэх төхөөрөмжүүд (хэрэгслүүд)	Түлш боловсруулах үйлдвэрүүд, бэлтгэх болон нэрэх байгууламжуудыг багтаасан биомасс, байгалийн хий болон шингэн, хатуу (жишээ нь ой мод) зэрэг биотүлш үйлдвэрлэх төхөөрөмжүүд (анаэроб боловсруулах байгууламжууд орно)	Нүүрстэй харьцуулахад агаарын бохирдлыг (PM2.5) дор хаяж 80% бууруулах
	2.1.2 Дулааны болон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх	Биомасс цахилгаан станцууд, биомасс цахилгаан дулааны станцууд, сайжруулсан биомасс зуух, хөдөө аж ахуйн болон ойн хаягдал ашиглах, үр тарианы хаягдалыг ашиглан цахилгаан эрчим хүч гаргах	
 2.2 Нүүрс орлуулах эрчим хүчний үүсвэрүүд	2.2.1 Хийн түлш ашиглан цахилгаан болон дулаан үйлдвэрлэх	Нүүрсний оронд байгалийн хий ашиглах эсвэл сэргээгдэх эрчим хүчтэй хослуулан хэрэглэн дулаан болон цахилгаан эрчим хүч гаргах байгууламжууд, байгалийн хийн станцын хаягдал дулаан ашиглах	
2.3 Хог хаягдлаас цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх	2.3.1 Хог хаягдлаас цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх цахилгаан станц	Хатуу хог хаягдлыг шатаах, хийн төлөвт хувиргах, өндөр температурт хайлмаг болгон хувиргаж цахилгаан эрчим хүч эсвэл дулаан гарган авах байгууламжууд	
 2.4 Түлш орлуулах	2.4.1 Эрчим хүчний салбарт түлш орлуулах	Цахилгаан эрчим хүчээр халдаг эсвэл шингэрүүлсэн хийгээр халдаг шийдэлрүү шилжих	
	2.4.2 Тээврийн хэрэгслийг цэнэглэхэд зориулсан болон түлш орлуулах дэд бүтэц	Энгийн шатахуун түгээгүүрийн газраас тусдаа тохиолдолд	

3 ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ			
Дэд ангилал	Технологи	Жишээ	Шалгуур
 3.1 Одоо байгаа үйлдвэрлэлийн байгууламжуудын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх	3.1.1 Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж болон технологийн сайжруулалт	Эрчим хүч илүү сайн хэмнэх тоног төхөөрөмжүүдийг суулган ашиглах, үйлдвэрлэлийн болон удирдах үйл ажиллагааг өөрчлөх, дулаан алдагдлыг бууруулах эсвэл дулааныг дахин ашиглах зэрэг байдлаар үйлдвэрүүдийн эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх төхөөрөмжүүд: ашигт үйлийн коэффициент өндөртэй нам даралтын зуух, компрессор, насос	Хүлэмжийн хийг 20% бууруулах
	3.1.2 Дулааны цахилгаан станц/ когенераци, тригенераци төхөөрөмж суурилуулах	Дулаан, цахилгааны хосолсон станцууд	
	3.1.3 Цахилгаан дамжуулах болон хуваарилах системийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх	Дамжуулах шугамыг дулаалах эсвэл шинэ дэд станцууд барих эсвэл сүлжээний тогтвортой/найдвартай байдлыг сайжруулах үйл ажиллагааг багтаасан эрчим хүчний хэрэглээ болон техникийн алдагдлыг бууруулах хуваарилах систем	
	3.1.4 Төвлөрсөн дулааны системүүд	Дүүргийн дулааны системүүдийг эрчим хүч хуваарилах станцууд эсвэл бусад тоног төхөөрөмжүүд ашиглан сайжруулах	
 3.2 Хэрэглээний болон олон олон нийтийн үйлчилгээний салбаруудын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх	3.2.1 Эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж	Хэрэглээний болон олон нийтийн үйлчилгээний салбаруудын эрчим хүчний хэмнэлтийг эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг болон тоног төхөөрөмж суулган ашиглах замаар сайжруулах	Хүлэмжийн хийг 20% бууруулах

	3.2.2 Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүд (эцсийн хэрэглэгчдэд зориулсан)	Эрчим хүчний хэмнэлттэй хөргөгч, зуух, угаалгын машин, халаагуур	Хүлэмжийн хийг 20% бууруулах, Energy Star шошготой байх
	3.2.3 Эрчим хүч хэмнэх үйлчилгээ	Аж үйлдвэрүүд, барилга байгууламжууд, тээврийн системүүд зэрэг эцсийн хэрэглэгчдэд зориулсан цахилгаан эрчим хүч хэмнэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, үүнд эрчим хүчний аудит, эрчим хүч хэмнэх чиглэлээр зөвлөгөө үйлчилгээ үзүүлэгч компаниуд (ЭСКО) багтана	Хүлэмжийн хийг 20% бууруулах
 3.3 Эрчим хүчний хэмнэлттэй барилга	3.3.1 Эрчим хүчний хэмнэлттэй шинэ барилга барих	Эрчим хүчний ашиглалт багатай барилга	Барилгын норм ба дүрмийг дагах, Эрчим хүчний паспорт авах, Ногоон барилгын стандартыг хангах
	3.3.2 Одоо байгаа арилжааны, нийтийн, орон сууцны болон үйлдвэрлэлийн барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх	Дулаан техникийн шинэчлэл (дээврийн шинэчлэл, дулаалга, гадна ханын дулаалга, цонх солих, халаалтын системийг шинэчлэх, ухаалаг тоолуур суурилуулах, гол орц хаалгыг шинэчлэх, зоорийн дулаалга)	

4 НОГООН БАРИЛГА			
Дэд ангилал	Технологи	Жишээ	Шалгуур
 4.1 Ногоон барилга	4.1.1 Ногоон барилга барих (арилжааны, нийтийн, орон сууцны болон үйлдвэрлэлийн барилгын)	"Эрчим хүч: Барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээг бууруулдаг өндөр үр ашигтай архитектурын зураг төсөл, эрчим хүчний хэмнэлттэй хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын техникийг ашиглах, Монгол Улсын ногоон байгууламжийн үнэлгээний стандарт эсвэл түүнтэй адилтгах эрчим хүчний хэмнэлттэй гэрчилгээ эсвэл үнэлгээний схемийг дагаж мөрдөх, Ус: Усны хэмнэлттэй тоног төхөөрөмж, тоног төхөөрөмжийг ашиглах, барилгын усны хэрэглээг багасгах, усны үр ашигтайг илтгэсэн гэрчилгээ эсвэл үнэлгээний баталгаажуулалттай байх, тухайлбал Монгол улсын ногоон байгууламжийн үнэлгээний стандарт эсвэл түүнтэй адилтгах олон улсын стандартын дагуу ашиглах. Материал: Ган эсвэл цемент гэх мэт үйлдвэрлэхэд их хэмжээний энерги шаардагдах материалын хэмжээг багасгаж, бага эрчим хүчээр үйлдвэрлэдэг, дахин ашигласан/дахин боловсруулсан материал ашигладаг байх	Эрчим хүч, ус, материалын ногоон стандартыг хангасан байх (EDGE Ногоон барилгын үнэлгээний систем, LEED, BREEAM гэх мэт)
 4.2 Ногоон барилгын материалууд болон бүтээгдэхүүнүүд	4.2.1 Ногоон барилгын материалууд болон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг, ногоон барилгын материалууд, эрчим хүчний хэмнэлттэй материалууд: органик ноосон дулаалгын материал, АҮК сайтай төхөөрөмжүүд: гэрэлтүүлэг, халаагуур, хөргөлтийн төхөөрөмжүүд, лифт, урсдаг шат, тоолуур, гүний дулааны насос	

4.3 Ногоон дэд бүтэц	4.3.1 Ногоон дэд бүтэц	Олон ашиглалт бүхий ногоон байгууламж (усан сан, амралт, биологийн төрөл зүйлийн коридор, явган болон дугуйн зам), үерийн усны хамгаалалт, гудамжны гэрэлтүүлэг, хогийн далангийн сайжруулалт	Эрчим хүч, ус, материалын ногоон стандартыг хангасан байх (EDGE Ногоон барилгын үнэлгээний систем, LEED, BREEAM гэх мэт)
	4.3.2 Гэр хорооллыг сайжруулах	Хашааг сайжруулах: одоо байгаа байшингийн дулаан техникийн шинэчлэл, эрчим хүчний хэмнэлттэй болон ногоон амины орон сууц шинээр барих, сайжруулсан ариун цэврийн байгууламж (септик, хог хаягдлыг дахин боловсруулах), цахилгаан болон цэвэр нүүрсний технологи, халаалтын дулааны насос, хорооллын дулааны сүлжээ, цахилгаан хуримтлуур, борооны усыг хуримтлуулах, саарал болон хар усыг дахин ашиглах, дахин боловсруулах, ногоон байгууламж, тохижилтын ажил	

5 БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА			
Дэд ангилал	Технологи	Жишээ	Шалгуур
 5.1 Агаарын чанар	5.1.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах, дахин боловсруулах байгууламжууд	Сүльфур болон нитритийг бууруулах, саармагжуулах байгууламжууд, шүүлтүүр, бүрэн шаталтат зуух	
	5.1.2 Гэр ахуй болон бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан халаагуурын тоног төхөөрөмжүүд	Цахилгаан халаагуур (шөнийн халаагуур, цахилгаан шалны халаалт, халаалтын хана)	Хүлэмжийн хийг 20% бууруулах
	5.1.3 Нүүрстөрөгчийг ангилан хадгалах технологи		
 5.2 Хөрс	5.2.1 Хөрсний бохирдол бууруулах болон сэргээх байгууламж болон дэд бүтэц	Бохирдсон эсвэл муудсан хөрсийг сэргээхэд зориулагдсан хөрс сэргээх технологи болон бүтээгдэхүүн ашигладаг дэд бүтэц, байгууламжууд	
	5.2.2 Гэр хороолол, жуулчны бааз болон жижиг бизнесүүдэд зориулсан зөөврийн болон эко жорлонгын шийдлүүд	Био жорлон, контейнерт суурилсан жорлон, хуурай жорлон	

6 ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ			
Дэд ангилал	Технологи	Жишээ	Шалгуур
 6.1 Тогтвортой ус ашиглалт болон ус хэмнэх	6.1.1 Ус хэмнэх, хэрэглээг хянах, хадгалах, хуваарилах технологи болон системүүд	Үйлдвэрийн үйл ажиллагааны ус хэмнэх, хэмнэлтийг хэмжих технологи, хөдөө аж ахуйн усны хэмнэлттэй усжуулах технологи, ус хэмнэлтийг хянах ухаалаг сүлжээ, салхи шуурга, зуд, үер эсвэл дам хаалт нурах зэргээс сэргийлсэн эрт илрүүлэх системүүд, усны чанар хэмжээг хянах үйл ажиллагаанууд, борооны усыг хураах систем, гадаргын усыг дахин цэнэглэх систем, усны сувгууд болон хуваарилах систем	Усны хэрэглээг 20% бууруулах
	6.1.2 Уламжлалт бус, шинэлэг технологитой усыг дахин ашиглах байгууламжууд	Уламжлалт бус, шинэлэг технологитой усыг дахин ашиглах байгууламжууд эсвэл дэд бүтэц, саарал ус дахин ашиглах болон дахин боловсруулах системүүд	
 6.2 Хог хаягдал болон хаягдал ус	6.2.1 Хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжууд	Хатуу хог хаягдлыг (эмнэлгийн болон хортой хог хаягдал мөн хамаарна) ангилах, боловсруулах байгууламжуудын үйл ажиллагаа болон байгууламжуудыг байгуулах	
	6.2.2 Хаягдал цуглуулах, ангилах болон нөхөн сэргээх, дахин боловсруулах байгууламжууд	Хаягдал цуглуулах, ангилах болон нөхөн сэргээх, дахин ашиглах болон дахин боловсруулах байгууламжууд. Барилгын материал, метал, хуванцар, шил, цаас, хаягдал цахилгаан тоног төхөөрөмжүүдийг дахин боловсруулах байгууламжууд	
	6.2.3 Органик нэгдлийг задлах компостны байгууламжууд	Органик хог хаягдлыг ашиглан компост үйлдвэрлэх байгууламжууд	
	6.2.4 Хаягдал ус цэвэрлэх байгууламжууд	Хаягдал ус цуглуулах сүлжээнүүд мөн хадгалах, боловсруулах байгууламжууд (Хаягдал ус боловсруулах үйлдвэр, лаг боловсруулах үйлдвэр, ундны ус цэвэршүүлэх, уснаас давс болон бусад эрдсийг ялгах, мөн бохироос ус лаг хоёрыг салгах)	

6.3 Нөөцийн хэмнэлт болон сэргээх байгууламж	6.3.1 Түүхий эд материал ашиглалтыг багасгах, ногоон болгох	Хортой бодисыг хоргүйгээр солих, анхдагч түүхий эдийг дахин боловсруулсан түүхий эдээр солих худалдан авалт	
--	---	---	--

7

ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР
АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ

Дэд ангилал	Технологи	Жишээ	Шалгуур
 7.1. Тогтвортой хөдөө аж ахуй	7.1.1 Органик хөдөө аж ахуй болон мал аж ахуйн бүтээгдэхүүнүүд	Дараах стандартуудыг хангасан хөдөө аж ахуй, мал аж ахуй, засаг агнуурын органик бүтээгдэхүүнүүд (боловсруулах байгууламжуудын үйл ажиллагаа болон байгууламжуудыг барих): 1) Органик бүтээгдэхүүн болон органик эсвэл ногоон бүтээгдэхүүнийг гэрчилгээжүүлэхтэй холбоотой үндэсний болон олон улсын холбогдох стандартууд 2) Мал амьтны эрүүл ахуй, хоол хүсний аюулгүй байдал, мал эмнэлгийн эм, эмчилгээ, бордоо болон химийн бордоо ашиглах зэрэгтэй холбоотой байгаль орчин болон чанар аюулгүй байдлын стандартууд 3) Усны хэмнэлт болон хог хаягдал боловсруулах зэргийг агуулсан тогтвортой хөдөө аж ахуй эрхлэх арга туршлага 4) Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг дэмжих үйл ажиллагаа: Мал амьтны эрүүл мэнд, мал аж ахуй, био шингээгч ашиглан малын ялгадас боловсруулах, хоол тэжээлийг сайжруулах, бүтээмжийг өсгөх зэрэгт чиглэсэн олон улсын болон үндэсний холбогдох гэрчилгээжүүлэлт авсан, USDA шошготой, чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл	
	7.1.2 Тогтвортой нэхмэлийн боловсруулалт, үйлдвэрлэл	Арьс шир боловсруулах аргыг зөвхөн өргөн хүрээний фермерийн аж ахуй эрхэлж байгаа тохиолдолд чанарын хяналт, тогтвортой нэхмэл /ноолуур /ноос/ сарлагийн үйлдвэрлэлийн стандартыг хангаж, эко будах технологи, химийн бодис, био агентуудыг ашигладаг; олон улсын болон үндэсний стандартад нийцсэн үйлдвэрлэлийн үйл явц, түүнчлэн түүний шингэн ба хатуу хог хаягдлыг боловсруулах стандартуудыг хангасан үйл ажиллагаа	Үндэсний "Хаан ширхэгт" стандарт, Хариуцлагатай нүүдэлчин шалгууруудыг хангасан байх, эсвэл олон улсын стандартыг хангах

	7.1.3 Тогтвортой бэлчээрийн ашиглалт болон мал аж ахуй	Газар хагалах, услах болон бусад төрлийн хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйл ажиллагаанд ус, цахилгаан эрчим хүч хэмнэх, газар ашиглалтыг бууруулах үйл ажиллагаа, газрыг үр ашигтай байдлаар тариалалтанд бэлтгэх, хөрс ашиглахгүйгээр ургамал тарих, малын тоог багасган бэлчээрийн менежментийг сайжруулах арга хэмжээ	
 7.2 Тогтвортой ойн менежмент болон ойг хамгаалах	7.2.1 Ойжуулах болон эргэн ойжуулах үйл ажиллагаа	Ой мод байхгүй газрыг ой моджуулах (мод тарих) эсвэл ой модтой газар дахин шинээр нэмж мод тарих, ой мод устах болон ой мод багассанаас шалтгаалсан хүлэмжийн хийг бууруулах	
	7.2.2 Тогтвортой ойн менежмент	Хамтарсан менежмент, мэдээллийн систем болон бусад холбогдох технологиудаар дамжуулан ойн үйл ажиллагааны нөлөөг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа	
	7.2.3 Тогтвортой байдлаар түлээ бэлтгэх мөн үртэс боловсруулах үйлдвэрлэл	Байгаль орчинд сөрөг нөлөө бага, тогтвортой байдлаар түлээ бэлтгэх мөн үртэс боловсруулах технологи нэвтрүүлсэн үйлдвэрлэлийн байгууламжууд, био нэрэлтийн байгууламжууд, дахин боловсруулж ашиглах	
	7.2.4 Биологийн олон янз байдал болон экосистемийг хамгаалалт	Эко системийн доройтлыг багасгах, нөхөн сэргээх үйл ажиллагаагаар дамжуулан биологийн төрөл зүйлийг хамгаалах төслүүд, экологийн үйлчилгээ бүхий талбайн (тодорхой ан амьтны амьдрах орчин, цөл, намгархаг газар) арчилгаа, нөхөн сэргээлт	
	7.2.5 Газрын менежмент	Хээрийн экосистемийг хадгалах, доройтсон газрыг нөхөн сэргээх, хөдөө аж ахуй эрхэлдэг газрын хөрсийг нөхөн сэргээх байгууламж, дэд бүтэц; байгалийн бэлчээрийн даацыг багасгах зорилгоор зүлэгжүүлэх, хашлага барих, ус хадгалах үйл ажиллагаа, газрыг нөхөн сэргээх, цэвэрлэх үйл ажиллагаанууд	
 7.3 Эко аялал жуулчлал	7.3.1 Эко аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээнүүд	Нөхөрлөл, бүлэг иргэдэд суурилсан жуулчлалыг хөгжүүлэх, байгалийн цогцолборт газаруудыг хамгаалах, хөгжүүлэх, байгалийн өв болон тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалах	
	7.3.2 Тогтвортой зочид буудал, жуулчны баазын менежмент	Олон улсын болон орон нутгийн тогтвортой аялал жуулчлалын стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, жуулчны бааз	

8 КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР			
Дэд ангилал	Технологи	Жишээ	Шалгуур
 8.1 Нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг тээврийн хэрэгсэл худалдан авах	8.1.1 Нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг тээврийн хэрэгсэл худалдан авах	Цахилгаан болон хосолсон хөдөлгүүртэй нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг тээврийн хэрэгсэл	
	8.1.2 Нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг үйлдвэрлэлийн сүлжээний төхөөрөмжүүд	Тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн үйлдвэрлэл, аккумулятор	
8.2 Нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг ачааны болон карго тээвэрлэлт	8.2.1 Нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг ачааны болон карго тээвэрлэлт	Цахилгаан болон цахилгаан бус ачааны тээврийн хэрэгслүүд	
 8.3 Цэвэр тээврийн дэд бүтэц	8.3.1 Олон нийтийн тээврийн хэрэгслийн дэд бүтэц	Замын тусгай зориулалтын эгнээнүүд, хурдны автобусны систем, олон нийтэд зориулсан явган алхах болон дугуй унах дэд бүтцүүд	
	8.3.2 Нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн дэд бүтэц	Цэнэглэх станцууд болон өөр түлшээр явдаг тээврийн хэрэгслийн түлш авах тусгайлсан дэд бүтэц (газрын тосоор хийсэн түлш авах станцуудаас ялгаатай)	
	8.3.3 Нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн төлөвлөлт	Тээврийн дэд бүтэц болон хотын хөгжлийн төлөвлөлтийг нэгтгэж иргэдийн хувийн тээврийн хэрэгсэл ашиглалтыг бууруулах	
8.4 Цэвэр тээврийн ухаалаг технологи	8.4.1 Тээврийн хэрэгслийн горимоос үл хамааран ашигт байдал, замын урсгал болон ачааллыг бууруулдаг ухаалаг технологи	Нийтийн тээврийн мэдээлэл түгээх, машин хуваалцах, ухаалаг картын системүүд	



Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо

Виста Оффис, 2 давхар
Энхтайвны өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: (976) 11 314105
Мэйл: info@toc.mn
Цахим хаяг: www.toc.mn